

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг нэг удаа хийж, 9 асуудал хэлэлцэн, 8 тогтоол гаргаж, бусад асуудлаар тэмдэглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өглөө.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын ирц 81,81 хувь байлаа.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнгийн тухай, Цэргийн дүйцүүлэх албыг 2020 онд хаах иргэдийн тоог батлах тухай, аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтын байдалд тандалт судалгаа хийсэн дүнгийн тухай, аймгийн мал аж ахуйн 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө батлах тухай, аймгийн төв суурингийн 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө батлах тухай, хөрөнгийн тухай *Хөрөнгө бүртгэлд авах, данс бүртгэлээс хасах, дуудлага худалдаа зохион байгуулах тухай* /, эмийн эргэлтийн сангийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал, аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай асуудал хэлэлцэв.

Төрийн захиргааны чиглэлээр

“Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нь” сургалтыг зохион байгуулж, сумдын ЗДТГ-ын дарга нарыг хамруулан төрийн жинхэнэ албан тушаалын тодорхойлолт батлах, сул орон тоог нөхөх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж 15 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Анхдугаар Үндсэн хуулиа баталсан өдрийг тохиолдуулан төрийн дээд одон, медалиар 14 иргэн шагнагдсныг гардууллаа.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Баян-Агт сумын Хануй ангархайн замын засвар, шинэчлэлийн ажилд 28.2 сая, Ойн хортны тэмцлийн ажилд 70.0 сая, Ойжуулалтын ажилд 31.8 сая, Ой бүхий сумдад ойн хортны судалгааны ажилд 14.9 сая, Усны тоо бүртгэлийн ажилд 6.4 сая, Булган сумын Майдарын голын эргийн хамгаалалт болон Диваажин сүмийн орчмын тохижилтын ажлын зураг төсөл, судалгааны ажилд 1.5 сая, Булган сумын ус дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмжийн өргөтгөл, шинэчлэлийн ажилд 46.0 сая, АЗДТГ-ын лед дэлгэц худалдан авах ажилд 10.0 сая, Тэшигийн Буриад зоны өв соёлын судалгааны ажилд 10.0 сая, Рашаант сумын хог хаягдлын цэгийг дарж булах, хашаажуулах, шилжүүлэх ажилд 8.4 сая, Булган аймгийн газар нутгийг илэрхийлсэн самбар хийж, хил орчмын бүсүүдэд байршуулах ажилд 29.1 сая, Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд хийгдсэн эссэ бичлэгийн уралдааны зардалд 1.0 сая, нийт 257.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар аж ахуй нэгж, байгууллагын ирцийн мэдээг 05 дугаар сарын 20-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.

Сангийн яамнаас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем”-ын онлайн сургалтад амжилттай хамрагдаж 7 сургагч багш бэлтгэсэн. Үүнтэй холбоотойгоор 16 сум 1 тосгоны “Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем”-ын сургалтыг зохион байгуулсан.

Суманд 602.6 сая, орон нутгийн төсвийн байгууллагуудад 1466.1 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 3318.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Улсын төсөвт 302.9 сая, аймгийн төсөвт 7359.8 сая төгрөг, сумын төсөвт 35.3 сая төгрөг төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

Орон нутгийн өмчит байгууллагуудаас хөрөнгийн хөдөлгөөн хийлгүүлэхээр ирүүлсэн материалуудыг 05 дугаар сарын 20-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.

Гурав: Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 3 хэргийн 3 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээ үзүүлэн 18 иргэнд хуулийн зөвлөгөө өгч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 5 дугаар сарын байдлаар 164 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.4 хувиар буурсан байна. Мөн 11014 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар буурсан дүнтэй байна. 2020 оны 5 дугаар сард Хулгайлах гэмт хэргээс мал хулгайлах буурсан, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7.5 хувиар өссөн, Хүрээлэн буй орчны гэмт хэргээс хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 57.2 хувиар өссөн, Хүчиндэх гэмт хэрэг 37.5 хувиар өссөн ба бусад гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна.

Архивын тасгийн чиглэлээр:

Лавлагаа авахыг хүссэн нийт 92 иргэнд 607 баримтаар үйлчилсэн. цалингийн 470, тушаалын 233 баримтаар үйлчилсэн. Үүнээс 102 иргэнд 245 хуулбарын лавлагаа, 83 иргэнд цалин, 39 иргэнд баримт байхгүй тодорхойлолт олгосон байна.

Цахимд оруулсан 95 байгууллагын баримтын тоо мэдээг Архивын ерөнхий газарт хүргүүлжээ.

Цахимд оруулсан:

Гурванбулаг сумын Ахуй үйлчилгээний төвийн 1980-1990 оны 10 хн, Кино театрын 1970-1984 оны 15 хн-ийг бүртгэлтэй тулган хүлээн авч тавиур дээр байрлуулаа.

Нөхөн бүрдүүлэлтээр : Барилга зураг төсвийн 137 хөмрөгийн 16 хн-ийн 1108 хуудас баримтыг жагсаалт ,aktaар хүлээн авлаа. Мөн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2003-2011 оны 19 хн-ийн 775 хуудас баримтыг данс, бүртгэлтэй хүлээн авлаа.

Үдэж хавтаслах талаар: Рашаант сумын Ургац ХК-ны тушаал, цалингийн баримтыг он оноор салгаж 1992-1994 оны 3 тушаал, 1993-1996 оны 4 цалин, нийт 7 баримтыг шинээр үдэж хавтаслав.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Төрөлт-107, Гэрлэлт-25, Гэрлэлт цуцлалт-2, Үрчлэлт-0, Нас баралт-21, Нийт шинээр олгосон иргэний үнэмлэх-64, Гадаад паспорт-12 Лавлагаа-154

Үй ёсгүй үлдээх ажиллагааны үр дүн:

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл-24, Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт-53, Гэрээний эрхийн бүртгэл-210, Барьцааны гэрээ-42 Эд хөрөнгийн бүртгэлд шинээр бүртгүүлсэн хувийн сууц-12, Хувийн сууц бэлэглэх гэрээ-0, Шинээр бүртгүүлсэн орон сууц-0, Орон сууц бэлэглэх гэрээ-3

Өрөөлөгчдийн үлдээх ажиллагааны үр дүн:

Шинэ бүртгэл-2, нэмэлт өөрчлөлт-3, татан буугдсан-1, тамга тэмдэг-0, лавлагаа-5

Бүртгэл хяналтын чиглэлээр:

Хяналт тавьсан бүртгэлийн тоо-45, Зөрчлийн шийдвэрлэлт-48, Иргэний бүртгэлийн чиглэлээр-32, ЭХЭБ-ийн чиглэлээр-24, Иргэний бичиг баримтын зөрчилтэй иргэдийн зөрчлийн хуулиар торгууль оногдуулсан-42

Төрийн архивын чиглэлээр нийт 106 иргэнд лавлагаа гаргасан 648 баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Шүүх шинжилгээний албан чиглэлээр нийт 19 хэргийн газрын үзлэгт оролцон 548 кадр гэрэл зургаар ул мөр бэхжүүлсэн. Илрүүлсэн гарын мөр 2, гутлын мөр 3, тээврийн хэрэгслийн мөр 7, бусад ул мөр, эд мөрийн баримт 5, нийт 17 ул мөр илрүүлж, ажилласан байна. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр кримналистикийн 7, цогцост 5, гэмтлийн зэрэг тогтоох 28, химийн шинжилгээ 9 хийж, билгийн шинжилгээ 5, нас тогтоох 1, папилон санд 18, хэргийн газраас бэхжүүлсэн нь 3, 18 иргэний гарын хээг оруулсан байна.

**Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд,
нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

Боловсролын чиглэлээр:

2019-2020 оны хичээлийн жил дуусч буй энэ хугацаанд бид бүхэн дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас сургууль, цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг хичээлийн жилийн 2 дугаар улирлаас эхлэн зогсоосон энэ цаг хугацаанд өөрсдийн нөхцөл байдалд тохируулж дэвшүүлэн тавьсан зорилт, бодлого, чиглэл, тэдгээрийн хэрэгжилтийг хангах, боловсролын үйлчилгээг хүргэх, багш, сурагч нэг бүрийг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа үр дүн, ахиц, дэвшил, алдаа, дутагдлыг үнэлж, хамтын хүчээр багагүй ажлыг амжуулсан хичээлийн жил байлаа. Хичээлийн жил дуусч сургалтын үйл ажиллагааныхаа чанар, үр дүнг хэмжих, ойрын хугацаанд анхаарах зарим асуудлын талаар 1/104 тоот бүхий Чиг үүргийг хавсралтын хамт хүргүүлэн 2020 оны 06 сарын 05 ны дотор хариу ирүүлэн хамтран ажиллахыг Бүх ЕБС, СӨБ-д үүрэг болголоо.

12 дугаар ангийн сурагчдад давтлага өгөх ажил эхэлсэнтэй холбогдуулан БСШУС-ын Сайдын 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн "ЭЕШ-д бэлтгэх, давтлага зохион байгуулах заавар" А/220 дугаар тушаалыг хүргүүлж танхимын сургалтаар давтлага хичээл хийх ангийн дотор зохион байгуулалтын талаар хэрхэн арга хэмжээ авч ажиллах ЭЕШ-д бэлтгэх давтлагын хуваарь боловсруулах талаар зөвлөмж, чиглэл хүргүүлсэн.

2019-2020 оны хичээлийн жил дуусах гэж байгаатай холбогдуулан Боловсролын салбарын мэдээллийн системд дараах зөвлөмж, бүртгэл мэдээлэл нээгдсэн тул Цэцэрлэгийн төгсөлт, дэвшилт хийх, Багшийн систем дээр ЕБС-ийн суралцагчийн жилийн эцсийн дүн бүртгэн оруулах, 2019-2020 оны хичээлийн жилийн 3, 4 дүгээр улирлын цахим журнал хөтлөх зөвлөмж, Цэцэрлэгийн төгсөлт, дэвшилтийн бүртгэлийн видео зөвлөмж, Элсэлтийн ерөнхий шалгалтын давтлагын ирцийн бүртгэлийг оруулах, Хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хичээлийн жилийн бүтцийг улирлаа зөв сонгож мэдээллээ оруулах талаар чиглэлийг бүх ЕБС, СӨБ-д хүргүүлсэн.

БСШУС-ын Сайдын 2020 оны 05-р сарын 07-ны өдрийн А/220 дугаар тушаал гарсантай холбогдуулан Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын, Ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд зохион байгуулахад мөрдөх зөвлөмжийг 12 жилтэй ЕБС-д хүргүүлэн, мэдээллийг авч нэгтгэн МХГ-т хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 139 дүгээр тогтоолыг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар "Бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл зогсоон, суралцагчдад зориулан зохион байгуулж байгаа теле болон цахим хичээлийг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх"-ээр шийдвэрлэсэнтэй уялдуулж "Багшийн журнал"-ыг үргэлжлүүлэн хэрхэн хөтлөх зааврыг хавсралтаар бүх ЕБС-д хүргүүлсэн

Эрүүл мэндийн чиглэлээр:

Дэлхийн олон улсад шинэ коронавирусын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, ЭМС-ын 2020 оны А/269 “Түр заавар шинэчлэн батлах тухай” дугаар тушаалын биелэлтийг хангуулах чиглэлээр Хангал, Орхон, Хишиг-Өндөр, Могод, Гурванбулаг, Рашаант, Дашинчилэн, Баяннуур сумдын ЭМТ-үүдэд дотоодын хяналт, үнэлгээ хийж зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.

"COVID-19" халдварт цар тахалтай тэмцэх бэлэн байдлын цахим дадлага сургуулилтад нийт 19 ЭМБ хамрагдсан ба ЭМ-ийн шуурхай удирдлагын нийт 11 хүний бүрэлдэхүүн 6 цагийн байдал дээр ажилласан. Сум, өрхийн ЭМБ-уудын эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээг 05 сарын 06-ны өдрийн 08 цагаас 05 сарын 08-ний өдрийн 15 цагийн хооронд нийт 34 удаагийн мэдээг цаг бүр ЭМХТ-д цахимаар илгээн ажилсан.

Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх 8 төрлийн зөвлөмж /Барилгын компани, ажилчдад өгөх зөвлөмж, үсчин, гоо сайхны салонд өгөх зөвлөмж, цэргийн анги, нэгтгэл, алба хаагчдад өгөх зөвлөмж г.м/ -ийг шинээр боловсруулан ЭМБ-ууд болон бусад төрийн, төрийн бус байгууллагуудад тараан ажиллаа. ЕБС-уудын төгсөх ангийнхны давтлага хичээл эхэлсэнтэй холбогдуулан курс, дамжаа, сургалтын төвүүдэд өгөх зөвлөмжийг боловсруулан Боловсрол соёл урлагийн газар, ЕБС-уудад хүргүүлэн ажилласан.

2020 оны 05 сарын 06-ны өдөр Эрүүл мэндийн төвийн удирдлага, зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор Рашаант суманд ажиллалаа. Ажиллах хугацаанд Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч болон архив бичиг хэргийн ажилтанд холбогдох зөвлөгөө, зөвлөмжийг өглөө.

“Эмийн цэцэглэн” ӨЭМТ-д сувилахуйн тусламж, хөнгөвчлөх, яаралтай тусламжид хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Эрүүл мэндийн газрын даргаар ахлуулсан баг Түлүүгийн давааны “Монгол зоог” цайны газрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуй, “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйа дадал” MNS CAC RCP 39:2011 стандартын хэрэгжилтийн талаар хяналт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Ерөнхий гэрээгээр нийлүүлэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах гэрээг 3 эм ханган нийлүүлэх байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 02 дугаар хурлыг 05 сарын 19 нд зохион байгуулж, 2 ЭМБ-ын тусгай зөвшөөрлийг сунгах, 1 эмийн санд тусгай зөвшөөрлийг шинээр олгох шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Хачигт энцефалитын вакциныг Шүүхийн тамгын газар, 1-р 12 жилийн сургуулийн ажилтан, албан хаагчид, аймгийн Онцгой комиссын гишүүд, Мал эмнэлгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын нийт 165 хүнд хийсэн.

Сумдын ЭМТ-үүдийн 2020 оны эхний 4 сард сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх цэрний сорьцын тээвэрлэлтэд хяналт хийхэд сумдын ЭМТ-үүдээс 33 цэрний сорьц тээвэрлэж, Баян-Агт, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Хутаг-Өндөр сумдын нийт сорьцны 63%-ийг зөөвөрлөсөн байна. Сорьц тээвэрлэсэн мэдээллийг сумдад эргэн мэдээлэлээр хүргүүлсэн.

ХӨСҮТ-өөс Тэмбүүг устгая үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хуваарилагдан тараасан ХДХВ илрүүлэх түргэвчилсэн оношлуур 400ш, Тэмбүү илрүүлэх түргэвчилсэн оношлуур 400ш, ХДХВ/Тэмбүү жирэмсэнд илрүүлэх DUO түргэвчилсэн оношлуур 400 ширхгийг хүлээн авсан.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2020 оны 05-р сарын байдлаар 5187 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаагаас идэвхтэй ажил хайгч 945, идэвхгүй ажил хайгч 4242 иргэн бүртгэлтэй байна. Шинээр 429 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлсэн байна.

Ажил олгогч 48 байгууллагаас 218 ажлын байрны захиалга авч, орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр байршуулан зар сурчилгааг явуулж ажиллалаа.

Шинээр бий болж байгаа ажлын байранд 209 ажил хайгч иргэн зуучлагдан ажиллаж байна. Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 289 ажил хайгч иргэн зуучлагдсан.

Хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 16 сум 1 тосгоноос 54 төсөл ирснээс 19, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 90 төсөл ирснээс 47, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 62 төсөл ирснээс 24, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 69 төслөөс 36 төслийг цаашид хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн.

Нийт 7 төрлийн тендерийн ажилд 21 компанитай ажиллах хүч нийлүүлэх гэрээ байгуулан ажиллалаа.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Халамжийн сангаас 2020 оны 5-р сард 6024 иргэнд 702,2 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт олгогдлоо. Монгол Улсын Засгийн Газраас коронавирусийн тархалтын үед авч хэрэгжүүлж байгаа 2 дахь багц арга хэмжээний хүрээнд халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа иргэд болон байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмж 100000 төгрөгөөр нэмэгдэж 288000 төгрөг болж нэмэгдсэнээр 27%-иар санхүүжилт нэмэгдсэн байна. Бүх сумдаас тэтгэвэр тэтгэмжийн хувийн хэрэг, нэг удаагийн хөнгөлөлтийн материалыг хүлээн авч хянан олголтыг хийсэн.

Аймгийн хэмжээнд 34 байгууллага нийт 165 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа ба төрлөөр нь авч үзвэл: хараа 32, сонсгол 20, хөдөлгөөний 50, хавсарсан 2, бусад төрлөөр 73 иргэн байна.

Байнгын асаргаа шаардлагатай 175 хүүхэд байна. Үүнээс эрэгтэй 106, эмэгтэй 69 хүүхэд байна. 0-3 насны хүүхэд 42, 4-7 насны хүүхэд 53, 8-11 насны хүүхэд 48, 12-16 насны хүүхэд 32 хүүхэд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан ажил олгох урамшууллыг “Эгийн хишиг” ХХК, “Шар тал” ХХК-ийн материалыг хүлээн авч баталгаажууллаа.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн дараах үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

Үзүүлэлт	Хүний тоо	Өртөг /мян.төг/
Халамжийн тэтгэвэр	1054	733127,0
Халамжийн тэтгэмж	1363	449031,4
Ахмад настанг асарч буй иргэнд НМТ	873	267725,7
ХБ-тэй иргэнийг асарч буй иргэнд НМТ	311	94558,9
Байнгын асаргаатай ХБ-тэй хүүхэд НМТ	176	80100,8
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсөн тэтгэмж	24	6645,9
Ахмад настанд үзүүлсэн тусламж/хөнгөлөлт	615	49963,5
ХБ-тэй иргэнд үзүүлсэн тусламж/хөнгөлөлт	146	18626,5
Амьжиргаа дэмжих сангаас олгосон/тусламж	1239	191417,1
Алдарт эхийн одон	5442	696600,0
Хүнс тэжээл хөтөлбөр	4470	164704,0
Алдар цолтой ахмад	29	18400,0
Цалинтай ээж	660	128339,0

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр:

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан сум, байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн дунд “Аз жаргалтай гэр бүл-3” 15 хоногийн аяныг зарлаж сайн зохион байгуулсан эцэг эхийн зөвлөлүүдийг шалгарууллаа. Тус аяны хүрээнд байгууллагын албан хаагчдыг Угийн бичгийн цахим сургалтад хамруулж, гэр бүл хөгжөөнт цахим тэмцээн, цөөн тооны алба хаагчдыг хамруулсан гэр бүлийн уралдаан, хүүхдийн дунд гар зураг, зохион бичлэгийн уралдаан зохион байгуулсан байна.

Дэлхийн болон Монголын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн Шилдэг гэр бүлүүдийг шалгаруулах удирдамжийг Булган аймгийн 16 сум, 1 тосгонд хүргүүлэн сумдаас материал хүлээн авлаа.

"ӨНӨР ГЭР БҮЛ"-ийн эзнээр Баяннуур сумын өндөр настан Ж.Доржсүрэнгийн гэр бүл
"ШИЛДЭГ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ, ОЮУНЛАГ ГЭР БҮЛ"-ийн эзнээр Булган сумын өндөр настан Ч.Бадамдоржийн гэр бүл

"ШИЛДЭГ АВЬЯАСЛАГ ГЭР БҮЛ"-ийн эзнээр Хутаг-өндөр сумын С.Мягмарын гэр бүл

"ШИЛДЭГ ЗАЛУУ ГЭР БҮЛ"-ийн эзнээр Бүрэгхангай сумын Ч.Батзоригийн гэр бүл

"ШИЛДЭГ БИЗНЕС ЭРХЛЭГЧ ГЭР БҮЛ"-ийн эзнээр Бугат сумын Б.Эрдэнэ-цогтын гэр бүл тус тус шалгарлаа.

Эрүүл ирээдүй аяны хүрээнд архинд хамааралтай иргэдэд зориулсан сургалт эмчилгээг 7 хоногийн хугацаанд зохион байгуулж байна. Энэ сургалтын зарыг 16 сум, 1 тосгонд хүргүүлэн архинд донтох эмгэгтэй иргэдээ хамруулах чиглэл өгсөн. Булган сум болон бусад сумдаас нийт 13 иргэнд энэ үйл ажиллагаанд хамрагдаж байна. Энэ үйл ажиллагааг Нэгдсэн эмнэлэг, Эрүүл идэвхтэй амьдралын клуб, эрх зүйн туслалцааны баг, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

2020 онд Монгол улсын Хүүхдийн төлөө зөвлөлийн 2018 оны тогтоолыг хэрэгжүүлж албан байгууллагуудад эцэг эхийн зөвлөл байгуулах чиглэлийг хүргүүлж аймгийн хэмжээнд 97 эцэг эхийн зөвлөл байгуулагдан жилийн ажлын төлөвлөгөөгөө гарган хэрэгжүүлж эхэллээ. Хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын чиглэлээр:

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан болж хүүхэд хамгаалалд тулгамдаж буй асуудлаар гишүүн байгууллагууд хэлэлцлээ.

Хүүхэд өсвөр үеийнхэнд ирээдүйн мэргэжлээ сонгоход чиг баримжаа олгох зорилготой ажил мэргэжлийн онцлогийг харуулсан “Мэргэжлээ мэдэж сонгоё” радио ярилцлагын 4, 5 дахь дугаарыг Сайхан Аялгуу 106,5 радиотой хамтран хийлээ. Уг ярилцлага, подкастыг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж ажилласан.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Мал аж ахуйн талаар:

Оны эхний төллөвөл зохих эх малын 71,3 хувь буюу 1177148 толгой эх мал төллөж үүнээс ингэ 151, гүү 43622, үнээ 63696, эм хонь 705325, ямаа 364354 төллөж, гарсан төл 93,8 хувьтай бойжиж байна.

Малын зүй бус хорогдлын мэдээг сум бүрээс авахад 107701 хорогдож үүнээс адуу 7563, үхэр 7376, хонь 65565, ямаа 27197 толгой хорогдож, оны эхний малын 2,15 хувийг эзэлж байна. Хамгийн их хорогдолтой сумын тоонд Сайхан 46686, Баян-Агт сум 31046, Могод 6125, , Орхон 5716, Хутаг-Өндөр 4959 толгой мал хорогдож хамгийн их малын хорогдолтой сумын тоонд орж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн хөнөөлт мэргэчидтэй микробиологийн аргаар Рашаант, Гурванбулаг сумдын бэлчээрийн 37.5 мянган га-д, энгийн механик аргаар Дашинчилэн, Баяннуур, Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдын бэлчээрийн 70.0 мянган га-д, орон нутгийн төсвийн хөрөнгөөр энгийн механикийн аргаар Могод, Орхон, Сайхан сумдын бэлчээрийн 40,0 мянган га, нийт 147,5 мянган га-д тэмцэх арга хэмжээг 04 дүгээр сарын 01-нээс 5 дугаар сарын 20-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсан.

Малын генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бод, бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх зорилгоор өсвөр хээлтүүлэгч бойжуулах ажлыг 5-р сарын 25-ны өдрөөс Дашинчилэн, Бүрэгхангай, Сэлэнгэ суманд зохион байгуулж байна. Уг ажилд мөрийн соёрхолт мал зүйч Г.Алтангэрэл болон МАА-н албаны мэргэжилтнүүд, сумдын ХАА-н мал зүйч нар хамтарч ажиллалаа.

Аймгийн ИХТ-ийн хурлаар 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын нэгдсэн төлөвлөгөөг оруулж, батлууллаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр гаргах инженерийн хийцтэй 30 худгийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Булган-Ус” ХХК, “Таширы хүрээ” ХХК, “БИММ” ХХК-уудтай гэрээ байгуулан ажлаа эхлэхэд бэлэн болсон.

Газар тариалангийн чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 32164 га-д үр тариа 159 га-д төмс, 53 га-д хүнсний ногоо, тосны ургамал 580 га-д тариалан үр тариа 73,2%, төмс 44,9%, хүнсний ногоо 40 % тай байна

Аймгийн хэмжээнд 05 сарын 28-ны өдрийн мэдээгээр бараа, бүтээгдэхүүний нөөц тогтвортой байна. Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүн мах, махан бүтээгдэхүүн 68,06тн – 11 хоног, гурил 64,28тн – 13 хоног, төрөл бүрийн будаа 11,82тн – 5 хоног, элсэн чихэр 10,99тн - 7 хоног, ургамлын тос 6,14тн – 5 хоног, өндөг 79000 ширхэг буюу 3,95тн – 4 хоног, давс 6,37тн – 25 хоногийн хангалттай нөөцтэй, гурилан бүтээгдэхүүн 10,38тн – 1 хоног, төмс 12,81тн – 2 хоног, хүнсний ногоо 7,82тн – 0,6 хоног, хуурай сүү 6,67тн – 1 хоногийн нөөцтэй байна.

Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Хутаг-Өндөр, Булган сум, Хялганат тосгон мэдээгээ өгөөгүй боловч “Булган Мах маркет” ХХК-ний 53,0 тн хонины мах “Баяндаш хайрхан” ХХК-ний бэлтгэсэн нөөцийн махны үлдэгдэл 9,0 тн үлдэгдлийг тооцож оруулсан.

Ихэнх сумын хүнсний нөөц, хангамж хэвийн татан авалт хэвийн байгаа. Иргэдийн худалдан авалт тогтвортой байна.

Бүх сумдад гурил, давс, элсэн чихэр хангалттай буюу 3-25 хоногийн нөөцтэй хүнсний ногоо, сүү, төмс, цэвэр усны нөөц маш бага байна. Айл өрхүүд худагаас усаа авдаг тул цэвэр усны нөөц харьцангуй бага байдаг. Мал төллөж сүү, цагаан идээний нийлүүлэлт эхэлсэн тул хангалт боломжийн байна.

Аймгийн төвийн хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлдэг нөөцөд мах 05 сарын 28-ны өдрийн байдлаар нийт 8700кг буюу 7500кг үхрийн мах, 1200 кг хонины махыг дэлгүүрүүдэд түгээсэн. Хонины махны түгээлтийг 06 сарын 01-ны өдөр хүртэл түр зогсоож, дан үхрийн махыг нийлүүлж байна.

ЖДҮХС-н төсөл зарлагдсанаас хойш 36 ААН, хоршоо бүртгүүлэн 35 бичил, 1 жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр тодорхойлолт авсан байна.

04 дүгээр сарын 20-ноос 5 дугаар сарын 19 -ныг хүртэл сарын хугацаанд 2.9 тэр төгрөгийн 33 төсөл хүлээн авч программ бүртгэж ажиллаа.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Монгол улсын Ерөнхий сайдын 01 тоот албан тоот даалгавар, аймгийн Засаг даргын А/154 тоот захирамжийн дагуу хийгдсэн сэг зэм устгал, ариутгал халдваргүйтгэлийн мэдээг гаргаж, МЭЕГ-т хүргүүлсэн. Үүнд аймгийн хэмжээнд 72890 мал амьтны сэг зэм устгаж, 1147620 м² нийтийн эзэмшлийн талбай, 100356 м² хашаа хороо, худаг уст цэг, өтөг бууц, 10072 м² бэлчээрийн талбай, 568 м² агуулах зоорь, 17373 м² устгалын талбай нийт 1275989 м² талбайд халдваргүйжүүлэлт хийсэн. Тус ажилд 962 хүн ажиллаж, 116 техник хэрэгсэл ашигласан.

Гоц халдварт шүлхий өвчний вакцинжуулалт болон халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын төлөвлөгөөт арга хэмжээ явагдаж байгаатай холбогдуулан малын шилжилт хөдөлгөөнийг 6 сарын 1 хүртлэх хугацаанд хязгаарлаад байна.

Зургаа: Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын чиглэлээр:

Байгаль орчны чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтээр мод тарих ажлыг Covid-19 өвчний хорио цээртэй холбоотойгоор нийтийг хамарсан байдлаар зохион байгуулах боломжгүй тул сум орон нутаг бага багаар тарилтын ажлыг хийж одоогийн байдлаар 2850 ширхэг мод таригдаад байна.

Газрын даргын 2020 оны А/30 дугаар тушаалаар Булган ус ХХК-нд Баяннуур, Бугат, Орхон, Булган, Хишиг-Өндөр сумдад ногоон байгууламжийн зориулалтаар 6, бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар 6 нийт 12 худаг гаргах зөвшөөрлийг олголоо.

Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан “Төсөлч” ХХК-ийн MV-016841 тоот, “Хамтын эх булаг” ХХК-ийн MV-016896 тоот, “Наран гоулд” ХХК-ийн MV-015424 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд 2018 он, 2019 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан, нөхөн сэргээлтийн ажлыг манай газарт хүлээлгэн өгөөгүй, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгээгүй тул Цагдаагийн газарт шилжүүлэх тухай албан бичгийг хүргүүлээд байна.

“Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага” ТББ нь судалгааны ажлыг 4-р сарын 20-ноос эхэлж Хангал, Сэлэнгэ, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр, Бугат сумын нутгаар механикаар гүйцэтгэх ажлыг талбайг судлан үзэж талбайг сонгон ажлыг хийлгэлээ.

30% Тэшиг сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Баян шинэс” ХХК-ийн “Зүсмэл материал үйлдвэрлэх” төсөлд БОНЕУ хийлээ.

Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх 1 дүгээр шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлууллаа.

Азийн сангийн хэрэгжүүлж буй Хог хаягдал ба уур амьсгалын өөрчлөлт төслийн цахим сургалтад 2 мэргэжилтэн хамрагдлаа.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Газар зохион байгуулалтын цахим системд Сумдын ИТХ-р батлагдсан 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг цахим системд дутуу оруулсан 29 нэгж талбарыг нөхөн оруулж, төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 нэгж талбарыг устган засвар мэдээллийг хийж гүйцэтгэлээ.

2019 онд Орхон, Бугат, Хутаг-Өндөр, Тэшиг, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Хангал сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд 294.0 сая төгрөг тусгагдсаны дагуу зөвлөх үйлчилгээний тендер зарлагдаж мэргэжлийн “Вектор мэл” ХХК шалгарч, аймгийн Засаг даргын 2019 оны А/386 дугаар захирамжийн дагуу нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын гэрээг байгуулан Булган аймгийн 7 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг ажлын даалгаварт тусгагдсан заалтын дагуу хийж гүйцэтгэсэн. 2020 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 7 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайлан, зургийг актын дагуу “Вектор мэл” ХХК хүлээлгэн өглөө.

Газрын төлбөр, үнэлгээний чиглэлээр:

Аймгийн хэмжээнд газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн иргэн аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газарт ногдуулсан газрын төлбөрийн өмнөх оны дутуу төлбөр болон тухайн жилийн төлбөрийн хэмжээг тооцсон судалгааг хүснэгтийн дагуу нэгтгэн хавсралтаар, сумдаас баталгаажуулан ирүүлсэн газрын төлбөрийн ногдуулалтыг CD-р 2020 оны 01/489 албан бичгээр татварын хэлтэст болон ГЗБГЗЗГ-т хүргүүлэв.

Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий төлөвлөгдсөн газруудад газрын цахим биржийн програм хангамж ашиглан дуудлага худалдааг зохион байгуулах талаар аймгийн ЗД-

ын 2020 оны А/152 дугаар захирамжийн дагуу 6 нэгж талбарын газрыг авто машины гараашны зориулалтаар олгохоор зарлаж, цахим хэлбэрээр зохион байгуулсан

Газрын дуудлага худалдааны орлого:

2020 онд аймгийн хэмжээнд газрын дуудлага худалдаанд 20 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгдсөн. Газрын бирж буюу m1e.mn вэб сайтад 5-р сарын 26-ны байдлаар Орхон сум 10 нэгж талбар, Бугат сум 2 нэгж талбарт, Булган сум 10 нэгж талбарт, Баян-агт сум үйлчилгээний зориулалтаар 1 нэгж талбарын газруудыг дуудлага худалдаагаар олгохоор тус тус зарласны дагуу Баян-Агт суманд 100м² газар 3030,0 мян.төгрөг, Сэлэнгэ суманд үйлчилгээний зориулалтаар 500м² газар 1150,0 мянган төгрөг, Булган суманд 10 нэгж талбар бүхий газарт 41000,0 мянган төгрөг, Орхон суманд 10 нэгж талбарт 10661,4 мянган төгрөг, аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий төлөвлөгдсөн газарт газар авто гараашны зориулалтаар 30м² газрыг 1330,0 мян.төгрөг, мөн дэнчинд 960,0 мянган төгрөг нийт 56801,0 мянган төгрөгийг тус тус аймаг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Геодези, зураг зүйн чиглэлээр:

Рашаант сумын ИТХ-ын даргаас Өвөрхангай аймгийн Бүрд сумтай хиллэх Монгол толгой, 1290 тоот өндөрлөг хэсэгт хилийн цэсийн маргаан гарсан тул шийдвэрлэж өгөх талаар ирүүлсэн албан тоотын дагуу Булган, Өвөрхангай аймгийн Газрын удирдлагын хэлтсийн дарга, Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Булган аймгийн Рашаант сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын ажлын албаны ажилтан, Засаг даргын орлогч, БОУХБ, Багийн дарга, Газрын даамал, Өвөрхангай аймгийн Бүрд сумын Засаг дарга, Газрын даамал, БОУХБ, Багийн Засаг дарга нарыг байлцуулан газар дээр нь хилийн цэсийн тодруулж 2 аймгийн хилийн цэсэд ямар нэгэн зөрчил маргаан байхгүй байна гэсэн нэгдсэн ойлголтод хүрлээ.

Тодруулалтын ажлыг гүйцэтгэхдээ дараах нотлох баримтуудыг үндэслэн тодруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд: Аймаг, сумын хилийн цэсийг баталсан АИХ-ын зарлиг, хилийн цэсийн зураг, солбицол, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГЗБГЗЗГ-аас Өвөрхангай аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн 2020 оны 5 сарын 18-ны өдрийн 2/1455 тоот албан бичиг.

Өвөрхангай аймгийн Бүрд сумын иргэд, малчид буруу тодруулсан, анхнаас манай аймгийн нутаг дэвсгэр байсан хэмээн хүлээн зөвшөөрөхгүй байсан бөгөөд мэргэжлийн байгууллагуудын хувьд нотлох баримтыг үндэслэн хилийн цэсийг тодрууллаа хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдол гаргах эрх нь иргэд, малчдад нээлттэй тул дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй гэдгийг тайлбарлан өгч ажилласан.

Газрын кадастрын хэмжилтийг нийт 31 нэгж талбар, үл хөдлөх эд хөрөнгөнд хийж гүйцэтгэснээс 15 иргэн, хуулийн этгээд газар болон үл хөдлөх эд хөрөнгийн зураглалыг мэдээллийн санд оруулж ажилласан. Дээрх үйл ажиллагаанаас 355440 төгрөгийг төрийн сангийн 100040029002 дансанд төвлөрүүлээ.

Газрын суурь судалгаа, мониторингийн чиглэлээр

2020 оны 05-р сарын 12 өдөр ГЗБГЗЗГ орон зайн мэдээллийн хэлтсээс зохион байгуулсан ЗҮ-3 хиймэл дагуулыг ашиглах боломж, 2020 оны 05-р сарын 20-ны өдрийн Парисын хэлэлцээрийг хүрээнд хэрэгжүүлэх МУ-ын ХААОБГА-ын салбарын ил тод байдлын тогтолцоог сайжруулах 3 өдрийн цахим сургалтад тус тус хамрагдлаа.

- Сургалтаар Collect eart програм дээр газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээг оруулах
- Дэлхийн агаарын дундаж температур дэлхийн хүлэмжийн хийд өөрийн оруулах хувь нэмэр CBIT буюу ил тод байдал
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах буюу уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

- Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал
- Газар ашиглалт, ой бусад газар ашиглалт салбарын сайжруулах асуудлууд
- Хүлэмжийн хийн тооллого хийх

Сургалтаар судалгааны цэгүүдийг ашиглан мэдээлэл цуглуулах дасгал ажил хийсэнтэй холбоотой санал асуулга хуудас хүргүүлэв. Төслийн хүрээнд нийт 4918 цэгт газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ ажиллахаар болсны дагуу ажлын өдрүүдэд хуваан нийт 115 цэгийн үнэлгээг хийн ажилласан.

Цагдаагийн газрын ирүүлсэн ашигт малтмалын орд газартай давхцалтай эсэх талаарх 3 газрын координатын мэдээллийг гарган хүргүүлэв.

Газрын кадастрын чиглэлээр:

Булган аймагт “Эрчим хүчний төсөл-2” төсөл хэрэгжиж байгаатай холбоотой айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагатай цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг хийхэд иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрын гэрээ, гэрчилгээ шаардлагатай тул эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбаруудыг гэрээ, гэрчилгээжүүлэх талаар сумын Засаг дарга нарт 2020 оны 01/111 дугаар албан тоотоор чиглэл хүргүүлээ.